

«МОНГОЛЫН ТУХАЙ СУДЛАЛ» СЭТГҮҮЛ БНМАУ-Д ХЭВЛЭГДЭВ

Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн «Монголын тухай судлал» сэтгүүлийн эхний дугаарыг Хөх хотноо хэвлэн гаргав. Сэтгүүлийн редакциас уншигч авгай нарт хандан бичсэн оршил хэсэгт сэтгүүлийн чиглэл зорилго бол Монгол орныг гүнзгий судлан ойлгож, Хятад, Монгол хоёр ард түмний найрамдлыг ахиулан, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, соёлын солилцоонд тус дөхөм үзүүлж, БНМАУ-ын зарим туршлагаас суралцах мөн түүнчлэн Монголын нийгмийг тал бүрээс нь шинжлэх ухааны арга барилыг чанд баримтлан ажил хэрэгчээр гүнзгий судлах явдал гэх тодорхойлжээ.

Тус сэтгүүлийн «Улс төр, гадаад харилцаа» буланд Хятад, Монголын найрамдлын нийгэмлэгийн ажилтан Сю Вэньсийн бичсэн «Монголын тухай судлал» сэтгүүл «Хятад-Монголын ард түмний найрамдлын гүүр байхыг хүснэм» өгүүлэлд манай хоёр орон өнө эртний уламжлалт найрамдлын харилцаатай бөгөөд сүүлийн жилүүдэд урьд тасарсан харилцаа хоёр талын хүчин чармайлтын үр дүнд улс төр, эдийн засаг, биеийн тамир, соёл, шинжлэх ухаан зэрэг салбарт сэргэн хөгжиж байгаа тухай өгүүлжээ. Хятад улс «дөрвөн шинэчлэлт» -ээ хэрэгжүүлэхэд дотоодын нэгдэл нягтралын зэрэгцээ олон улсын амгалан байдал хэрэгтэй байгааг зохиогч заан тэмдэглээд, хятад, монголын ард түмний сайн хөршийн найрсаг харилцааг ахиулан сайжруулах үүднээс бодитой, шинжлэх ухааны байр сууринаас БНМАУ-ыг судлан, түүний социалист бүтээн байгуулалттай системтэй танилцан, харилцаагаа янз бүрийн шугамаар өргөжүүлж, хоёр орны найрамдал, хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх хэрэгтэй байна гэжээ.

1978 оны III бүгд хурлаас хойш ХКН том, жижиг, хөгжингүй, хоцрогдсон, капиталист, социалист алин болохыг үл харгалзан аливаа орны тэргүүн туршлагаас суралцан, ололт амжилт, алдаа эндэгдлээс туршлага, сургамж авах чиг шугам баримтлах болсныг Буянарвин «Монгол судлалын тухай өгүүлэх нь» өгүүлэлдээ дурьдаад, Өвөр Монголын хувьд өөрийн орны мужуудын туршлагаас гадна социалист бүтээн байгуулалтдаа олон жилийн баялаг туршлага хуримтлуулсан, тэгээд ч нутаг дэвсгэр, байгаль цаг уур, хүн амын нягтшил, нөөц баялаг, эдийн засгийн зарим талаараа ижил төстэй БНМАУ-ын өнгөрсөн, одоо ирээдүйг судлах явдал зохих ач холбогдолтой гэжээ. «Улс төр, гадаад харилцаа» буланд «МАХН-ын дөрвөн программын тухай өгүүлэх нь» (Насан) өгүүлэл, «БНМАУ-тай дипломат харилцаа бүхий орнуудын жагсаалт» (Наран) зэрэг материалууд орсон байна.

Сэтгүүлийн «Эдийн засаг» буланд 60-аад оны сүүлчээр манай оронд туршин нэвтрүүлж байсан аж ахуйн шинэ системийн тухай, одоо өрнөж буй эдийн засгийн шинэчлэлийн тухай өгүүлсэн «Монголын эдийн засгийн шинэтгэл» өгүүлэл болон монголын хөдөө аж ахуй аж үйлдвэржиж буй үйл явц, монголын аж үйлдвэрийн хөгжилтийн зарим асуудал зэрэг хэд хэдэн өгүүлэл хэвлэгджээ.

Хөдөлмөрчдийн соёл техникийн боловсролын түвшнийг дээшлүүлэх арга зам, энэ талаар гарсан ололт амжилт, монголчуудын хөдөлмөрийн хүмүүжлийн тухай өгүүлэлүүд сэтгүүлийн «Соёл боловсрол, шинжлэх ухаан, техник» буланд орсон байна,

«Монголын тухай судлал» сэтгүүлийн эхний дугаарт манай улсын эрдэмтдийн бүтээлээс, тухайлбал Д. Цэрэнсодном, Г. Сүрэнжав нарын бичсэн «Хятадын уран зохиол монгол нутагт аман зохиолоор дэлгэрсэн нь», «БНМАУ-ын шинжлэх ухаан техникийн хөгжил, түүний онцлог» өгүүллүүдийг орчуулан тавьжээ.

Сэтгүүлийн «Хүмүүс» буланд манай орчин үеийн уран зохиолын үндэс суурийг тавилцсан их зохиолч Д. Нацагдорж, С. Буяннэмэх нарын амьдрал, уран бүтээл, Монголын хөгжмийн нэрт зохиолчдын товч намтар, зохиол бүтээлийн тухай өгүүлэл, танилцуулга оржээ.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, хүн ардын зан заншлын тухай танилцуулах «Байгаль орчин, зан заншил» буланд эртний Монголын нийслэл Хархорум, тал нутгийн цэнхэр сувд-Хөвсгөл нуурын тухай материал хэвлэгдсэн байна.

Сэтгүүлийн төгсгөлд «Монголын түүх, соёлын дурсгал» (Д. Майдар М., 1982 номын танилцуулга оруулжээ.

«Монголын тухай судлал» сэтгүүл БНХАУ-д хэвлэгдэх болсон нь дэлхийн монгол судлалын цар хүрээ тэлж, судлаачдын эгнээ өргөжин байгаагийн нэг илрэл бөгөөд Монгол, Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн хөрш орны ард түмнүүд бие биеэ ойлгон, социалист байгуулалтын ололт амжилт, арга туршлагаа харилцан үзэж танилцахад сайхан бололцоо олгож байна.

Д. Шүрхүү

**НЬЮ-ЙОРК-ВАШИНГТОН-
ПРИНСТОН**

(Замын тэмдэглэл)

Доктор Ш.САНДАГ

Монгол орны маань зуны аагим халуун өдөр үргэлжилнэ. Анхны ногоо соёолж, хөхрөн ягаарах униар татсан Монгол нутаг маань юутай сайхан. Улаанбаатар дээгүүр хөглөгөр үүлс хуран цугларч, хур бороо нэлээд сууж орох янзтай дуслал нь алс холын Америкийг зорьсон бидний «алтан шарга» зам саадгүй байна гэж шивнэж байгаа юм шиг бодол төрүүлнэ. Хуртай жил болж, дэлгэр зун ирж, хөдөө тал маань сэргэж тэнүүн сайхан болох нь гэж баярлахын сацуу холын замын алжаалыг санаж эрхгүй бага зүрхшээнэ...

Тэгээд зуны тэр нэгэн өлзийт сайн өдөр БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Н. Содном тэргүүтэй төлөөлөгчид бид АНУ-ын шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн америкийн зөвлөлийн (ЭЙСИЛСИ) урилгаар АНУ-д албан ёсны зочлолт хийхээр одсон билээ.

Бид ниссээр Москва орж, тэнд АНУ-ын элчин сайдын яаманд виз мэдүүлсэнд ашгүй түргэн бүтэж, цааш аян замаа үргэлжлүүлэх боллоо.